

УДК 821.512.36

doi: 10.18101/978-5-9793-0054-2-2017-268-274

## С. БУЯННЭМЭХИЙН УРЛАН ЗОХИОХ ШИНЖИЙН ТУХАЙ

### © Өлзийжаргал

докторант, Международный педагогический институт, Университет Внутренней Монголии КНР

КНР, 010020, г. Хух-Хото, ул. Западная Университетская, 235

E-mail: wlj321com@126.com

С. Буяннэмэхийн онол өгүүлэхүй дэх урлан зохиох шинж нь түүний шүлгийн зохиол, үргэлжидсэн үгийн зохиол, жүжгийн зохиолоор дамжин илэрчээ. Тэр хувьсгалаас өмнөх үеийн байдал жич хувьсгалын байдлын «дүүрэн худал бус» ор «сэдэв»-т суурилан, өөрийн бүтээлч хөдөлмөрөөрөө «нэмж чимэх» зэргээр урлан боловсруулаад, шинэ үзэл санааг ухуулсан уран бүтээлүүдийг туурвиж байжээ. С. Буяннэмэх утга зохиолыг нэгэн биеэрээ даасан шинжлэх ухааны харьяагаар ойлгож, уран зохиол ба бичиг зохиолын зууралдсан үзэгдлийг туйлбартай ялгаж, монгол онол өгүүлэхүйн нэгэн онолын системийг бүрэлдүүлжээ. Тэр мөртөөн энэхүү урлан зохиох шинжээ онолжуулан хураангуйлж дүгнэж чадсан байна.

**Түлхүүр үг:** уран зохиол; шүлэг, жүжиг; С. Буяннэмэх; намтар судлал; уран бүтээл; ур чадвар; онол; туурвилзүй; үзэл санаа.

Эртний Грегийн бодосч үзлийн гүн ухаантан нар уран бүтээлийг бодит байдлын өнгөн талын хуулбар биш харин «Байгалийг дуурайлгах» буюу бодит ахуй байдлыг идэвхтэйгээр тусгаж байгаа хэрэг гэж үзэж байжээ. Энэхүү үеийн бодосч үзлийн гүн ухаантны төлөөлөгч Аристотель «Туурвил зүй» гэх зохиолдоо «Байгалийг дуурайлгана» гэдгийг яг таг хуулна гэсэн утгаар биш, аж амьдралд байдгаас ондоо зүйлийг бүтээлчээр нээнэ гэсэн утгаар ойлгож байжээ. Тэр «Туурвил зүй» гэх зохиолдоо юуг дуурайлгах вэ? гэдэг асуулт дэвшүүлээд нэг ч тохиолдлын зүйг биш, байж болох үнэн магадтай зүйлийг дуурайлгах естой гэж хариулжээ. Аристотель уран бүтээлч хүн зохиол бүтээлдээ юу байгааг дүрслэх естой биш харин «Үнэмшилтэй буюу магадтайн үүднээс тохиолдох байсан» [Ван Мандуга, 1999а, 7-тал] юмыг үзүүлнэ. Өөрөөр хэлбэл ургуулан сэтгэнэ гэж үзжээ. Энэ мэтээр зайлшгүй магадтай зүйлийг дүрслэхийг зааснаараа уран сайхны сэтгэлгээ, шинжлэх ухааны сэтгэлгээ хоёрын зааг ялгааг гаргаж «Яруу найрагч нь түүхийг бодвол илүү сүрхий чухал, ухааны чанартай» [Ван Мандуга, 1999а, 7-тал] гэжээ. Аристотель уран бүтээлч хүн, хүний зан төрхийн учир зүйд нэвтэрч, уран сэтгэмжийн тусламжаар хүний хэрэг явдлыг нөхцөлдүүлэн бодож олох юм гэж үзжээ. Аристотель нар уран бүтээлийг бодит байдлын өнгөн талын хуулбар биш, харин байгалийг дуурайлах буюу бодит ахуй байдлыг тусгаж байгаа хэрэг гэж үзэж байжээ. «Утга зохиолын онолын хөгжлийн сэргэн мандалтын үеийн нэгэн тэргүүн магнай болох Д. Винч урлагийн эх булаг байгал (үнэн байдал) мөн гэдгийг тунхаглаад түүнийг дуурайлгахдаа үнэн байдлын үзэгдэл, явцыг маш гүнзгий мэдэж байх шаардлагатай, энэ үүднээс уран бүтээлч бол *багш* мөн, үнэн бодитой байдал бол *багшийн багш* мөн гэж урлаг утгазохиолд юм үзэгдлийг дэмий балай хуулбарлан буулгахыг эрс буруушаасан байна» [Ван Мандуга, 1999а, 8-тал]. Бодит ахуйг үнэн зөвөөр дүрслэх нь

сэргэн мандалтын үеийн гарамгай зохиолчдын чухал баримтлал болох юм.

Арван есдүгээр зууны оросын хөрөнгөтөн ангийн хувьсгалт ардчилсан үзэлтэн Белишки дүр дүрслэлээр амьдралыг дахин ххаруулах бол утга зохиолын урлагийн үндсэн онцлог мөн гэж үзсэн байна. Түүний үзэхээр бодит ахуй бол урлагийн суурь мөн. Утга зохиол урлаг эрхбиш амьдралд шударга байх хэрэгтэй. Утга зохиол урлаг амьдралыг тусгахад хэв шинжүүлэх арга хэрэглэж «дүрслэгээр сэтгэх хэрэгтэй». Уран санаалгаар бодит амьдралыг цомхотгож бодит ахуйн мөн чанарыг илрүүлэх хэрэгтэй. Чернышевски урлагийн мөн чанарыг «амьдралыг дахин илрүүлж», «амьдралыг шүүмжлэн тодорхойлж», «амьдралын үзэгдлийг нотлон батлах» явдал мөн гэж үзэж байв. «Амьдралын харуулах» ба «сэтгэлгээг илрүүлэх» хоёр талаас утга зохиолын мөн чанар, бэлгэ шинжийг хураангуйлж тушаах судалгааны ажил, утга зохиолын онолын түүхэнд гол байрыг эзэлж байжээ.

Монгол уран зохиолын онол таниварын анхны үр хөврөлийг ундлан бойжуулсан «Зохист аялгууны толь»-д Дандинаас «чимэг» гэх онол ухагдахуунаа тайлбарлахдаа «зохист аялгууг үзэсгэлэн болгогч номнуудыг чимэг хэмээн сайтар өгүүлмөй» гэжээ. Б. Гэрэлт профессороос «Дандины хэрэглэсэн *чимэг* буюу *утгын чимэг* гэх ухагдахуунуудыг үндсэндээ *яруу найргийг эв хавлаг болгох арга дам, утгын чимэг гэдэг нь утга зохиолын агуулгыг төгөлдөр илтгэх хэл найруулгын зүй зарчим* гэж ойлгож болно» [Гэрэлт, 1985, 28-р тал] гэсэн билээ.

Монгол онол өгүүлэхүй нь өөрийнхөө хөгжлийн явцдаа утга зохиолын онолын чухал асуудлыг хөндсөөр иржээ. Монгол зохиолчид өөрийн зохиол бүтээлийн бодит үйлдэлгэдээ суурилан онолын гүнзгий асуудлыг хөнджээ. Инжинаш ба С. Буяннэмэхээс утга зохиолын онцлог шинжийн талаас тайлбар хийсэн юм. Тус хоёр зохиогч нь амьдралын бор материалд «нэмж чимэх» урлагийн боловсруулал хийвэл сая урлагт хүрч чадна гэсэн үзэлтэй. Энэхүү «нэмж чимэх» урлагийн боловсруулал нь даруй амьдралынхаа үнэнээс урлагийн үнэн хүрэх утга зохиолын онцлогийг ярьжээ. Энэхүү онцлог шинжийг нь тус өгүүлэлдээ би урлан зохиох шинж гэж нэрлэсэн байна. Дурдууштай нь өвөр монголд утга зохиолын энэхүү онцлог шинжийг олон янзаар нэрлэж ирсэн юм. Даруй ард сэтгэмж, баялаг сэтгэмж, зохион сэтгэмж, хий сэтгэмж, уран санаа, зохион бодохуй, хийсвэрлэн сэтгэх гэх зэргээр нэрлэсэн байдаг. Утга зохиол бол нийгмийн амьдралын тусгал мөн. Утга зохиол, үг хэлний материалаар уран дүрийг бүтээж, ахуй амьдралыг харуулдаг нийгмийн үзэл ухамсрын онцгой хэлбэр, утга зохиол нь нийгмийн амьдралаас сэдэвлэж уран сэтгэмжээр дамжин урлан зоиовол сая гоо сайхны гайхварлаг уран бүтээл болдог.

Инжинашаас утга зохиол бол нийгмийн бодит амьдралын «ор сэдэв» дээр «учир шалтгаан нэмж, салаа сүеэ ургуулан» урлаж зохиох явдал мөн гэж үзжээ. «Хөлөг судар»-ын товчит толтын төдгөөр ангид «тэдгээр сул шастир өчүүхэн бичгүүд хэмээгч цөмөөр өчүүхэн төдий ор сэдэв байваас мэргэдээр даруй түүнд зуун зүйлийн учир шалтгаан нэмж салаа сүеэ ургуулан, түмэн мянган давхар чимэх уянга нэмж, өөрийн оюунаа дэлгэрүүлэн өгүүлэл санаанаан орчлонд хоцруулан, тэр бичгийг үзээгүйд амттай болгожээ» [Гэрэлт, 1986, 74-р тал] гэжээ. Энд Инжинаш амьдралын «ор сэдэв» дээр утга зохиолын «зуун зүйлийн учир шалтгаан нэмж, салаа сүеэургуулан, түмэн мянган давхар чимэх уянга нэмэх» гэдэг нь утга зохиол нь амьдралаас эх авч бодит

амьдрал дахь хэрэг учраар сэдэвлэж, дүрслэг сэтгэхүйн үүднээс сэтгэхүйн ажиллагаагаар дамжин, холбон бодолт, ард санаа, уран зөгнөлөөр дамжин урлагийн үнэнд хүрэх ес учрыг амьдлаг ярьсан юм.

С. Буяннэмэх утга зохиолыг нэгэн биеэрээ даасан шинжлэх ухааны харьяагаар ойлгож, уран зохиол ба бичиг зохиолын зууралдсан үзэгдлийг туйлбартай ялгаж, монгол онол өгүүлэхүйн нэгэн онолын системийг бүрэлдүүлжээ. С. Буяннэмэх «ер аливаа үлгэр тууж нь уран зохиол гэгдэх тул эрхбиш нэмж чимэх зэргээр эвлүүлэн найруулж бүтээснээр яг тийм уран зохиол болжээ» [Ван Мандуга, 1999, 227-р тал] гэж уран зохиол нь нийгмийн хуулбар биш гэдгийг тодорхойлж, урлагийн үнэнийг «нэмж чимэх» гэх оновчтой үгээр хураангуйлж чаджээ. С. Буяннэмэхийн «алив үлгэр тууж нь эрхбиш тийм нэгэн явдал болсон буюу тийн нэгэн хүн үнэхээр тэр туужид хэлсэн мэтээр явсан учир сэдэв байснаас үүдэгдэн зохиогдсон нь төлөв ба эсвэл тэрхүү үлгэр туужид өгүүлсэн явдал үнэхээр огт байгаагүй хэрэг боловч харин тэр мэт хэрэг явдал нь ерөнхийдөө хүний дунд байгаа буюу байж болох учиртай амуй. Тиймийн тул цөмийг бүрэн дүүрэн худал гэхэд бэрхтэй ажээ» [Вандуга, 1999, 227-р тал] гэсэн нь С. Буяннэмэхээс Инжанашийн үзэлтийг улам гүнзгий тодруулж чадсан байна. Хоеул бүр утга зохиол амьдралаас сэдэв авч байгааг тодруулж, амьдралыг тэр хэвээр нь хуулан буулгаж болохгүй, зохиогч амьдралд байгаа буюу байж болох учир сэдвээр нэмж чимэх урлан зохиож бичдэг ес учрыг ярьжээ.

Инжинаш ба С. Буяннэмэх нь адил бус цаг үеийн хүн боловч тэр хоерын утга зохиол урлагт хандсан овор үзэлт, онол судалгаа нь ойртож байгаа нь тов тодорхой. Энэ бол үндэсний онол өгүүлэхүйн залгамжлал буюу. Инжанаш урлан зохиох шинжийн тухай таньж таньж тодруулж чадсан бол С. Буяннэмэх энэхүү онол үзэлтийг улам системтэй шинжлэх ухаанч чанартай болгосон нь үзтэл тодорхой.

С. Буяннэмэхээр харанхуй нийгмийн харгис хэрцгий ял гэмийг нэвт таньж, ард түмнээ гаслангийн далайгаас аврах шинэ замыг эрэлхийлэн монголдын ард түмний эрх чөлөөний төлөө тэмцэх хувьсгалын замыг сонгож авсан юм. С. Буяннэмэх «үнэн суртал зорилтыг олон түмэнд даруйхан нэвтрүүлэн нийтээр нь нэгэн лүгээ сайшаалган элсэж, намын хэргийг хөгжүүлэх чин үнэн эрмэлзлээр «Ардын намын тухай анхны шүлэглэл»-ээ зохиож хэвлүүлэн олон түмэнд хүртээхээр зорьж» [Хорлоо, 1985, 336-р тал] байжээ. Энэ нь түүний хувьсгалын уран зохиолч болохынх нь анхны оролдлого болов. С. Буяннэмэхийн уран бүтээлийн үйлсийн зам шүлгийн айзмаар найрагдан эхлээд, олон тиг стилийн зохиолуудаар баялагжиж ирсэн байдаг.

Д. Чимэдээс С. Буяннэмэх бол «одоо үеийн шинэ хувьсгалын авьяас бүхий зохиолч залуучуудын дундаас нэн ялангуяа үндэстний байгалийг магтах ба хуучин дарлагдлын доторх ядуу зүдүүгийн зовлон, баян элбэгийн байдал мэтийг чимэгтэй уянгатай бөгөөд үнэнээр зохиоход тодорч байгаа ардын зохиолч» [Ван Мандуга, 1999б, 668-р тал] мөн гэжээ. С. Буяннэмэхийн яруу найргийн утга сэдэв болон урлан зохиох шинжийн тухай Д. Чантуу нар «С. Буяннэмэхийн яруу найргийн гол сэдэв бол ардын хувьсгал юм. тэгэхдээ нэг л хэвээр ижил зүйлийг цугтаж байсангүй. Шинэ үеийн сургаал, эх орны магтаал, гүн ухааны сэтгэмж, багалийн уянга зэрэг өнгө аяс баян бөгөөд тэр бүхнийг гагцхүү хувьсгалт шинэ үеийн монгол хүний харьцааны үүднээс дүрсэлж байсан байна. үүний зэрэгцээгээр монголын яруу найргийн шүлэглэх тогтол-

цоонд бичгийн зохиолын уламжлал, зөвлөлтийн яруу найргийн туршлага, хувьсгалын шинэ бодит байдлын хэмлэлийг хослуулах гэж оролдож байсныг анхаарах хэрэгтэй» [Хорлоо, 1985, 350-р тал] гэж дурджээ.

С. Буяннэмэх хувьсгалын их үйлсийг ард түмэн бүхнээрээ дамжин, хувьсгалд оролцохыг уриалан «Хувьсгалч баатар эрсүүдийн / Хурц зориг шантаршгүй / Хувьсгалыг шүтсэн ардууд бид / Хүчийг нэгтгээд тусалъя» гэж шүлэглэж байсан мөртөөн, намын ач гавьяаг нартай өглөөний «Нам» гэсэн шүлэгтээ: «Нар нар гэж / Мянгантаа эс давтавч / Навч цэцэг дэлгэрэхэд / Илч хүчийг нь мэдэрдэг / Нам нам гэж / Түмэнтээ эс өгүүлэвч / Насны жаргалаа олоход / Ач гавьяаг нь санадаг» [Буяннэмэх, 1968, 62-р тал] гэж шүлэглэж байсан юм. С. Буяннэмэх өөрийн эх орноо зүрхний судас шиг аминчлан хайрлаж бахарч шүтэж явснаар: «Өргөн говьд нь турхан шувууд жигүүр цуцсан / Өндөр ууланд нь тураг ангийн хөл эцэнхэн / Монгол хэмээх ганцхан газар дэлхийн нэр биш / Монгол хэмээх ган зоригт баатар баатар түмэн» гэж бичсэн юм. Түүний энэхүү эх орноо гэсэн оргилом халуун хайр сэтгэлгээ нь түүний хувьсгалын төлөө тэмцэх идэвхжилийг хөвчилж, хувьсгалт шүлэг болон ухуулгын шүлгийнх нь түлхэц хүчин болж байсан юм.

С. Буяннэмэхийн яруу найргийн урлан зохиох шинж нь монгол соелынхоо хөрсөнд суурилж, хувьсгалын уриагаар шижимлэгдэн хэлхэгдэж байснаар барахгүй үргэлжилсэн үгийн зохиолын олонх нь ч нийгэм хувьсгалын байдал жич суртал ухуулгаар сэдэв болгон бичгдэж байсан байна. С. Буяннэмэхийн бичсэн «Ленин» гэх нийтлэл, «Жинчин Пүрвийн жигтэй явдал», «Ядуу нэгэн хоньчин» өгүүллэг зэрэг нь бүр л хувьсгалын байдал шинэ үзэл санааг ухуулсан байдаг. Үүнээр барахгүй «Харанхуй засаг» зэрэг жүжиг нь монголын хувьсгалаас өмнөх үеийн байдлыг тодорхой харуулсан, урлагч чанараар өндөр бүтээл болох юм. Тэр нь «Амьдралын утга чанарыг нээж, хүмүүсийн сэтгэхүйн хөдлөл, зан төрхийн онцлогийг үзүүлэхэд алхам болжээ. Энэ зохиолын бичлэгийн арга барил нь аман зохиолын дүрслэлийн уламжлалыг дэлхийн тэргүүний уран зохиолын туршлагатай хослуулснаар онцолсон юм» [Хорлоо, 1985, 375-р тал].

С. Буяннэмэх уран зохиолын эл тиг хэлбэрээр олон бүтээл туурвиж байсан бөгөөд, өөрийн зохиол оролдлогын туршлагаа үндэслэн, монголын хувьсгалын уран зохолын хөгжлийн тухай судлан шинжилж байжээ. Тэр «шүлэгч нар хянамуу?», «уран зохиолын зүйлийг хэрхэн зохиох сэдэв», «холбоо шүлгийн журмын тухай», «утга зохиолын үүд зэрэг», «шинэ үеийн уран зохиол» зэрэг өгүүлэл зохиол бичиж, өөрийн зохиол бүтээлийн урлан зохиох тухай санал болон үзэлтээ дэвшүүлж байсан юм. Тэр «хувьсгалын уран зохиол бол амьдралын баримтыг тэр чигээр хуулах биш, харин амьдралын үзэгдэл явдлын бодит үнэнийг нээж уран сайхнаар дүрслэн үзүүлэхийг эрхэмлэж байлаа» [Хорлоо, 1985, 384-р тал]. С. Буяннэмэх «Утга зохиолын үүд» гэх бүтээлдээ утга зохиолын туурвилын ерөнхий арга маяг болон утга учирын тухай өгүүлж, зохиол туурвихад юуны өмнө «шалгаж шинжих, урлаж бичих»-ийг уялдуулсан байх хэрэгтэй гэжээ. Энд хэлж байгаа «шалгаж үзэх» гэдэг нь амьдралын бор материал даруй «сэдэв хэрэглэхүүн»-ийг сайтар сонгон эмхлэх явдал болно. Даруй бичих гэж байгаа зохиолынхоо утга сэдэв, сэдэвлэсэн материал, зохион туурвих чиглэлт зорилгоо гүнзгий нягталж тогтоосон суурин дээр сэтгэн зохиомжилж, урлан бичвэл зохино гэж үзсэн байна. Тэр бас «урлаж бичихдээ урьд хожид үзэгдээгүй буюу хүнээс эрхбиш гойд бичихийг чухалчлах хам-

гийн эрхэм болой» [Ван Мандуга, 1999б, 261-р тал] гэж чухалчлан заасан байдаг.

С. Буяннэмэх «үлгэрчилсэн өгүүлэл»-ийг «үүнийг бичих маяг нь үнэн байдлаас авч үлгэр болгон бага зэрэг нэмж чимж уран яруу өгүүлэл найруулгатайгаар бичих» [Ван Мандуга, 1999б, 370-р тал] бөгөөд «үүний гол байгуулалт журам нь эрхбиш нэгэн хүний бие дээр боловч үнэндээ олон нийт лугаа холбогдсон байдалтайгаар бичих естой зүйл болно» [Ван Мандуга, 1999б, 380-р тал] гэжээ. Энд тэр «үнэн байдал»-аас авч «нэмж чимж», «өгүүлэл найруулга»-тайгаар бичихийн улмаас «олон нийт лүгээ холбогдсон байдал» болгон бичих утга зохиолын «сурган хүмүүжүүлэх» үйлдлийг ч чухалчилжээ. Үүнээр барахгүй тэр «тууж» гэдэг нь «ер хүний явдлаас үүссэн түүхт байдал нь уран сайхнаар үлгэрчлэн бичихийг буюу улсын хэргээс үүсэн олон зүйл явдлыг үлгэрчлэн бичсэнийг хэлнэ» [Ван Мандуга, 1999б, 381-р тал] гэж үзсэн бөгөөд «эдүгээ бол хувьсгалын туужнууд, хувьсгалын журамт сайн эрсийн явдал, түүний төлөө тэмцсэн байлдаан, ялагдсан элдвийн онц сонирхол бүхий зүйлүүд байна» гэж туужийн утга сэдвийн тухайн цаг үеийн бодит байдалтайгаа уялдуулан дурджээ.

С. Буяннэмэх түүх бичлэг болон «түүхэн уран зохиол»-ын ялгааг зөвөөр заан гаргаж, түүх ба түүхт үлгэр гэж тус тусад нь нэрийдэж байсан юм. Тэр «түүхт үлгэр хэмээгч даруй уран зохиолд холбогдоно. Юу хэмээвэл зарим улс төрийн байдал явдлаас үүссэн үнэн хэргийн түүхт тэмдэглэлийг даруй уран яруу өгүүлэлтэй болгож үлгэрчлэн бичиж уншихад зохистой уран зохиол найруулгатай болгосныг үлгэрчилсэн түүх хэмээнэ» [Ван Мандуга, 1999б, 386-р тал] гэж «түүхэн уран зохиол»-ын урлан зохиох шинжийн тухай санал баримтлалаа зөвөөр дурдаж байв. Тэр жүжгийн зохиолын урлан зохио шинжийн тухай «тэр нь үнэн болсон ямар нгэн сонин хэргээс сэдэв авах буюу байж болох хэргүүдийг сэдэвлэж түүнээ үзэгдэл бүрт онц сонирхол бүхий хөдөлгөөн тэмцэл уран арга санаачлагыг өргөнөөр нэмэгдүүлэн зохиож жинхэнэ уран сайхан жүжгийн найруулга болгоно» [Ван Мандуга, 1999б, 387-р тал] гэсэн бөгөөд цаашид жүжгийн байгуулалтын тухай «хүний дунд үүссэн нэгэн өчүүхэн ч атугай үнэн хэргийн байдал явдлаас авч түүний үүссэн шалтгаан ба түүний тэмцэлдсэн байдал хийгээд эцэст юу болсныг сайтар олж сурвалжилж мэдээд дараад түүнийг урлан бичиж үзэсгэлэнт сонирхолтой жүжиг болговол болно» гэж үзжээ.

С. Буяннэмэхээс зохиолч хүн өөрийн бэлтгэсэн «өврийн дэвтэр» дэх амьдралын жижиг сажиг үнэн бодит хэрэг учир, үйл явдлын тэмдэглэл нь утга зохиолын сэдвийн эх хэрэглэхүүний «(<материал) нөхцөл болж хэзээ юу зохиоход үлгэр жишээ болох зүйлүүдийг авах ба мөн түүний дотроос зохистой зүйлийг тусгай сэдэв болгож болно» [Ван Мандуга, 1999б, 387-р тал] гэжээ. Тэр бас уран зохиол нь «хэлж найруулах нь уран сайхан ба утга санаа нь ил далд болох хийгээд уншивч ханашгүй байх естой болно» [Ван Мандуга, 1999б, 394-р тал] гэж хэл найруулгын уран ба утга сэдвийн гүн нарийн байх тухай өгүүлжээ. С. Буяннэмэх «утга зохиолын үйлдвэр»-тээ «ер аливаа үлгэр туужийн зохиол дахь хэлэлцсэн, хийсэн, ярьсан, явсан хэрэг бүр, үг бүр цөм үнэн тийм байсан гэх нь төлөвгүй бөгөөд бас аливаа үлгэр туужид гарч байгаа явдал нь цөм худал гэж хараахан үл болох учир байна. Юу гэвэл аливаа үлгэр тууж нь эрхбиш тийм нэгэн явдал болсон буюу тийм нэгэн хүн үнэхээр тэр туужид хэлсэн мэтээр явсан учир сэдэв байснаас үүдэгдэн зохиогдсон нь

төлөв ба эсвэл тэрхүү үлгэр туужид өгүүлсэн явдал үнэхээр огт байгаагүй хэрэг боловч харин тэр мэт хэрэг явдал нь ерөнхийдөө хүний дунд байгаа буюу байж болох учиртай амуй. Тиймийн тул цөмийг дүүрэн худал гэхэд бэрхтэй ажээ. Ер аливаа үлгэр тууж нь уран зохиол гэгдэх тул эрхбиш нэмж чимэх зэргээр эвлүүлэн найруулж бүтсэнээр сая тийм уран зохиол болжээ» [Ван Мандуга, 1999б, 218-р тал] гэж хураангуйлан дүгнэжээ. Амьдралын үнэнийг урлагийн үнэнд хүргэх зохиогчийн үүргийн тухай «дээрх нь үнэн хэрэг боловч хэрэв тууж болговол эрхбиш нэмж чимэх зэргээр туйлын сайхан бөгөөд уншиахад бахтай уйдашгүй салшгүй болгох естой болно» [Ван Мандуга, 1999б, 230-р тал] гэж үзэхийн хамт «хэрэв нэмж чимэхгүй бол зөвхөн түүх тэмдэглэл мэт болох ба ер ч нэмж чимэхгүй бол тэр бүрийг сүүдэр мэт салшгүй дагаж яваагүй тул яахин хэлэлцсэн хийсэн нэг бүрийг мэдэх билээ. Бас хэрэггүйг хасч, дутагдалтайг нэмэхгүй бол зөвхөн тэмдэглэгч бичээч болохоос бус яахин зохиолч болох билээ» [Ван Мандуга, 1999б, 230-р тал] гэж урлагийн үнэний үнэ цэнийг зөвөөр үнэлсэн байна.

С. Буяннэмэхийн онол өгүүлэхүй дэх урлан зохиох шинж нь түүний шүлгийн зохиол, үргэлжидсэн үгийн зохиол, жүжгийн зохиолоор дамжин илэрчээ. Тэр хувьсгалаас өмнөх үеийн байдал жич хувьсгалын байдлын «дүүрэн худал бус» ор «сэдэв»-т суурилан, өөрийн бүтээлч хөдөлмөрөөрөө «нэмж чимэх» зэргээр урлан боловсруулаад, шинэ үзэл санааг ухуулсан уран бүтээлүүдийг туурвиж байжээ. Тэр мөртөөн энэхүү урлан зохиох шинжээ онолжуулан хураангуйлж дүгнэж чадсан байна.

### **Ном зүй**

1. Буяннэмэх С. Түүвэр зохиол. Улан-Батор, 1968.
2. Ван Мандуга. Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл. Өвөр монголын соелын хэвлэлийн хороо, 1999.
3. Ван Мандуга. Утга зохиолын онолын удиртгал. Үндэсний хэвлэлийн хороо, 1999а, 4-р сар.
4. Ван Мандуга. Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1999б. 8 сар.
5. Гэрэлт Б. Монгол зохиолын онолын чимэг. Өвөр монголын соелын хэвлэлийн хороо, 1985.
6. Гэрэлт Б. Монгол зохиолчдын шүүмж өгүүлэл (1721–1945). Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1986.
7. Дуйнхэржав Г. Сономбалжирын Буяннэмэхийн улс төрийн намтар. Улан-Батор, 1997.
8. Хорлоо, Лувсанвандан, Мөнх, Чантуу. Монголын орчин үеийн уран зохиолын түүх (дээд). Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1985, 4-р сар.
9. Энхбаяр С. С. Буяннэмэхийн уран зохиолыг үзэх үзэл // Таван ухаан. 1996. 1-р хугацаа.
10. Энхбаяр С. Утга зохиолын онол, туурвилзүй. Улан-Батор, 2000.

*Ulziijargal*

Inner Mongolia University

235, East University Rd, Huh-Hoto, 010020 China

The author considers art skill of one of the first playwrights of Mongolian People's Republic, an honored writer of MPR S. Buyannemekh on material of his poetry, prose and dramatic art. The author concludes that S. Buyannemekh takes as a basis the reality of pre-revolutionary time, decorating the narration with art means, bringing the new ideas. He has created a new literature character, the theory of the Mongolian literature of modern times. New conflicts and unknown plots appeared in his works for the first time.

**Keywords:** literature, verse, drama, S. Buyannemekh, biography, work, artistic skill, theory, composition, idea.